

## МОНГОЛЫН МЭРГЭШСЭН ҮНЭЛГЭЭЧДИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу мэргэшсэн үнэлгээчдийн ёс зүйн харилцааг зохицуулахад энэхүү дүрмийн зорилго оршино.
- 1.2. Мэргэшсэн үнэлгээчдийн ёс зүйн дүрмийг (цаашид ёс зүйн дүрэм гэх) Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институт (ММҮИ)-ийн гишүүн үнэлгээчид дагаж мөрдөнө.
- 1.3. Үнэлгээний Олон Улсын Стандартын Консулаас баталсан Олон Улсын Үнэлгээчдийн Ёс Зүйн Дүрмийн агуулгад нийцүүлэн ёс зүйн дүрмийг боловсруулсан болно.

### Хоёр. Монголын мэргэшсэн үнэлгээчдийн ёс зүйд хамаарах асуудал

- 2.1. Үнэлгээчин ямагт үнэнч шударга, өндөр ёс суртахуунтай байж үйлчлүүлэгч, олон нийт, мэргэжил, үндэсний мэргэжлийн байгууллагуудад хор уршиг учруулахгүй байхаар үйл ажиллагаагаа явуулах ёстой.
- 2.2. Үнэлгээчний үүрэг хариуцлага нь үйлчлүүлэгч болон ажил олгогчийн хэрэгцээг хангах, төдийгүй нийтийн ашиг сонирхолыг хангах байдлаар тодорхойлогдоно.
- 2.3. Үнэлгээчин **Үнэлгээний Олон Улсын Стандартын Консулаас** баталсан ёс зүйн дүрэм болон түүнд нийцүүлэн гаргасан мэргэжлийн байгууллага/Институт/-ийн дүрмийг дагаж мөрдөнө.
- 2.4. **Институт нь Олон Улсын Үнэлгээчдийн Ёс Зүйн Дүрэмд заасан үнэлгээнд учруулж болзошгүй зүйлийн хор уршиг болон хамгаалалтын талаар тайлбар хийх ёстой.**
- 2.5. Үнэлгээчин нь Институтийн дүрэмд заасан гишүүний эрх, үүрэг болон ёс зүйн дүрмийн шаардлагуудыг биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн нэр хүндийг унагасан аливаа үйлдлийг ёс зүйн зөрчил гэж үзнэ.
- 2.6. Үнэлгээчин нь үнэлгээний үйл ажиллагаатай холбоотой хууль, стандарт, дүрэм, журам, аргачлал болон институтийн баталсан дүрэм, журам, аргачлалыг мөрдлөг болгоно.

### Гурав. Монголын мэргэшсэн үнэлгээчний ёс зүйн үндсэн зарчимууд

#### 3.1. Шударга байх

- 3.1.1. Үнэлгээчин аливаа асуудалд хандахдаа хууль зүйн болон мэргэжлийн үүднээс **үнэнч, шударгаар** хандана;
- 3.1.2. Үнэлгээчин худал, буруу, нэг талыг барьсан үнэлгээ хийж үйлчлүүлэгч болон ажил олгогчийн ашиг сонирхолд автагдахгүй байх;
- 3.1.3. Үнэлгээчний дүгнэлтийг засварлах, өөрчлүүлэх талаар дарамт шахалт үзүүлснээс шударга болон бодитой байдал алдагдахад хүрч болох тул бусдын эрхшээлд орж болзошгүй аливаа нөхцөл бий болохоос урьдчилан сэргийлж байх ёстой;
- 3.1.4. Үнэлгээчин нь ямар ч нөхцөлд мэргэжлийн ёс зүйг сахин шийдвэр гаргахдаа бодит байдлыг эрхэмлэж байвал зохино;

## ТӨСӨЛ

- 3.1.5. Мэргэжлийн үйл ажиллагааны стандарттай зөрчилдөх үйлдлийн талаар үйлчлүүлэгч эсвэл дээд удирдлагын зүгээс мэргэшсэн үнэлгээчинд дарамт шахалт үзүүлсэн, эсвэл биелүүлэхийг шаардсан үед асуудлыг шийдвэрлүүлэх үүднээс дээд шатны удирдлагад хандана;
- 3.1.6. Дээд шатны удирдлагад танилцуулсны дараа ч ёс зүйд харшлах байдал байсаар байвал тухайн ажил/гэрээ захиалга/-ыг гүйцэтгэхээс татгалзана;
- 3.1.7. Мэргэшсэн үнэлгээчин ажил үүргээ гүйцэтгэхэд хамтран оролцож байгаа албан тушаалтан туслахууд нь үйл ажиллагаандаа энэ дүрмийг мөрдлөг болгоно.

### 3.2.. Мэргэжлийн ур чадвартай байх

- 3.2.1. Үнэлгээчин нь тухайн гэрээт захиалгыг чанартай гүйцэтгэхэд мэргэжлийн шаардлага хангасан нөхцөлд захиалгыг хүлээн авна;
- 3.2.2. Аль нэг үйлчилгээг үзүүлэхэд өөрийн мэргэжлийн мэдлэг, чадвар, туршлага дутагдалтай гэж үзвэл тухайн үйлчилгээнээс татгалзвалз охино;
- 3.2.3. Үнэлгээчин нь үйлчилгээ үзүүлэхдээ шаардлагатай гэж үзвэл хуульч, инженер гэх мэт нарийн мэргэжлийн мэргэжилтэнг урьж хамтран ажиллаж болно;
- 3.2.4. Үнэлгээчин нь үнэлгээний арга зүйн чиглэлээр гарч байгаа шинэ мэдээллийг байнга судалж, институтээс зохион байгуулж байгаа сургалт, хэлэлцүүлэгт жилд 2-оос доошгүй удаа оролцож мэдлэг чадвараа дээшлүүлсэн болохоо нотолсон байх ;
- 3.2.5. Үнэлгээчин үйлчлүүлэгчийн захиалгыг цаг хугацаанд нь үр бүтээлтэйгээр гүйцэтгэх ба ажлын явцын талаар үйлчлүүлэгчид байнга мэдээлж байх ёстой;
- 3.2.6. Үнэлгээчин буруу зөрүү ойлголт гаргахгүй байх үүднээс үнэлгээ хийхийн өмнө үйлчлүүлэгчээс бичгээр үйлдсэн дэлгэрэнгүй мэдээлэл авсан байвал зохино;
- 3.2.7. Үнэлгээний судалгаа мэдээлэл үнэн зөв, үүнд найдаж болно гэдгийг батлах үүднээс үнэлгээчин нарийн нямбай лавлагаа, судалгаа хийсэн байх ёстой;

### 3.3. Бодитой (Хараат бус) байх

- 3.3.1. Үнэлгээчний үйл ажиллагаа нь бие даасан, хараат бус шинжтэй байна;
- 3.3.2. Үнэлгээний үнэ, хөлстэй холбоотойгоор доорх нөхцөл байдал үүссэн бол үнэлгээчний хараат бус байдал алдагдсан гэж үзэх тул түүнээс урьдчилан сэргийлж байвал зохино:
  - а. Үнэлгээчний үзүүлсэн өмнөх үйлчилгээний хөлс төлөгдөөгүй тохиолдолд дараагийн үйлчилгээ хийвэл;
  - б. үнэлгээний эцсийн үр дүнтэй холбож хөлсний хэмжээг тогтоох;
  - в. үйлчлүүлэгчийн удирдах ажилтанд гэрээт ажлын хөлснөөс ямар нэг хэмжээгээр өгөх нөхцөлтэйгөөр үйлчилгээ үзүүлэхээр тохирох;
- 3.3.3. Үнэлгээчний эсвэл түүний гэр бүлийн гишүүн /эхнэр буюу нөхөр, хүүхэд эцэг, эх/ үйлчлүүлэгч байгууллагаас бэлэг, дурсгалын зүйл авах, бараа үйлчилгээг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдан авах нь хараат бус байдалд нөлөөлсөн гэж үзнэ. Энэ тохиолдолд тухайн бэлэг, дурсгалын зүйл буюу хямдруулсан үйлчилгээнээс шууд татгалзвал зохино;
- 3.3.4. Үйлчлүүлэгч байгууллагаас үнэлгээчдийн эсрэг шүүхэд зарга үүсгэх, сүрдүүлэх эсвэл үнэлгээчид үйлчлүүлэгчийн эсрэг шүүхэд заргалдахаар мэдэгдэх нь хараат бус байдалд нөлөөлж болох тул энэ тохиолдолд дараах зарчмыг баримталвал зохино. Үүнд:

## ТӨСӨЛ

- а/ элдэв зарга үүсч болох үйлчилгээг хийхээс татгалзах;
- б/ аливаа дүгнэлтийн нотлох баримт материалыг нягт нямбай бүрдүүлэх, нотлох баримтгүй тохиолдолд дүгнэлт өгөхөөс татгалзах;

### 3.3.5. Дараах ашиг сонирхолын зөрчил гаргахаас сэргийлж байвал зохино:

- а/ Санхүүгийн болон бусад сонирхолын нөлөөлөлд орохгүй байх ;
- б/ Бусад үнэлгээчний хувийн хувийн үзэл баримтлалын нөлөөлөлд орохгүй байх ;
- в/ Танилын хүрээний саад бэрхшээлийн нөлөөлөлд автагдахгүй байх.
- г/ Бусдын сүрдүүлэг, дарамт, шахалтад автагдахгүй байх.

## 3.4. Мэдээллийн нууцыг хадгалах

- 3.4.1. Үнэлгээчин үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцыг чандлан хадгална. Тэдэнтэй ажил төрлийн харилцаа холбоогоо тасалсны дараа ч мэдээллийн нууцыг хадгалах үүрэг хүчинтэй байна;
- 3.4.2. Үнэлгээчин өөрийн туслагчид уг зарчмын талаар мэдлэг эзэмшүүлж, дагаж мөрдүүлэх үүрэг хүлээнэ;
- 3.4.3. Мэдээллийн нууцыг хадгалах гэдэг нь мэдээллийг бусадтай хуваалцахгүй байхын зэрэгцээ мөн уг мэдээллийг хувийн эсвэл аль нэгэн гуравдагч талын ашиг сонирхол, давуу талд ашиглуулахгүй байх талаар үнэлгээчдийн хүлээх **хариуцлага** юм;
- 3.4.4. Үнэлгээчин нь дараах тохиолдолд мэдээллийн нууцыг хадгалах үүрэг хариуцлагаас чөлөөлөгдөж болно:
  - а/ Төрийн байгууллагын болон хууль, хяналтын бусад байгууллагын хяналт шалгалтад шаардлагатай баримт материал, мэдээлэл, нотолгоог тэдний шаардлагаар гаргаж өгөх;
  - б/ Хууль, эрхзүйн баримт бичгүүдэд шаардсан тохиолдолд хууль, эрхийг зөрчсөн үйл ажиллагааны талаар мэдээлэх.

## 3.5. Мэргэжлийн нэр хүнд, зан төлөвийг дээдлэх.

- 3.5.1. Институтээс тогтоосон шалгуураар мэргэжлийн үнэлгээчний зан чанар, мэдлэг, чадвар, туршлагатай болохоо нийгэм болон мэргэжлийн хамт олонд харуулж чаддаг байх;
- 3.5.2. Үнэлгээчин ёс зүйн дүрмийг хэрхэн сахиж байгаа талаар ММУИ-д тухайн жилийн ёс зүйн тайланг дараа оны нэгдүгээр улиралд багтааж ирүүлж байх;
- 3.5.3. Үнэлгээчин ёс зүйн дүрмийг биелүүлээгүй бол өөрөө хариуцлага хүлээж чаддаг байх;
- 3.5.4. Хууль, дүрэм, журмыг чанд мөрдөж, үнэлгээний стандарт, аргачлалыг оновчтой сонголт хийж үнэлгээнд ашигладаг байх;
- 3.5.5. Үнэлгээчин нь мэргэжлийн нэр хүндийг дээдлэн, түүнд харшлах аливаа үйлдлээс татгалзах ёстой.

## **Дөрөв. Мэргэшсэн үнэлгээчдийн мэргэжлийн үйлчилгээний чанар**

- 4.1. Нийтэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн үнэлгээчдийн үйл ажиллагаанд чанарын хяналтын тохиромжтой бодлого, горимыг хэрэгжүүлэх үүргийг түүний ажилладаг мэргэжлийн үйлчилгээ эрхэлдэг байгууллага хүлээнэ. Энэ үүргийн хэрэгжилтийг холбогдох төрийн эрх бүхий байгууллага болон Институт хянана.

## ТӨСӨЛ

- 4.2. Үнэлгээний үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, хөрөнгийн үнэлгээчид нь нийтэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхдээ тухайн үйлчилгээний чанарын стандартыг хангаж чадах түвшинд чанарын хяналтын бодлого горимыг дотооддоо тогтоож, түүнийгээ хэрэгжүүлдэг байхыг шаардана. Энэхүү горим нь мэргэжлийн үйлчилгээний цар хүрээ, үнэлж байгаа объектын онцлог, газар зүйн тархалт, зохион байгуулалт болон үйлчилгээний үнэ хөлс зэрэг олон хүчин зүйлээс хамааран ажил тус бүрд ялгавартай байвал зохино.
- 4.3. Мэргэшсэн үнэлгээчин нь гагцхүү олон нийтийн итгэл найдварыг баттай хүлээсэн нөхцөлд л мэргэжлийн энэхүү үйлчилгээг нийтэд тогтмол үзүүлж, энэ байдлаа хадгалж чадна хэмээн үздэг байх ёстой.
- 4.4. Ажил дууссаны дараа үнэлгээчид ажил тус бүрээр цаасан буюу электрон хэлбэрийн ажлын тусгай хавтсанд бүх бичгэн тайлан, шуудан тэмдэглэлийн үнэн зөв хуулбар, үнэлгээний лавлагаажсан санал, бодит харьцуулалт, тооцоолол зэрэг ашиглагдсан мэдээллийг таваас доошгүй жилийн хугацаанд хадгална.

### **Тав. Зар, сурталчилгаа, өрсөлдөөний үеийн ёс зүй**

- 5.1. Институтийн гишүүдийн талаар явуулах зар, сурталчилгаа нь үнэлгээчдийн үзүүлж буй үйлчилгээний тухай бодитой мэдээг олон нийтэд хүргэх явдал юм. Энэхүү зар сурталчилгаа нь шударга, зүй зохистой, үнэлгээчид болон үйлчлүүлэгчдийг аливаа төөрөгдөлд оруулахааргүй байх ёстой.
- 5.2. Дараах шинж чанар, утга санааг агуулсан зар сурталчилгаа нь мэргэжлийн ёс зүйд үл нийцнэ.
  - а/ Худал хуурмаг буюу ирээдүйд нааштай үр дүнд хүрнэ гэсэн бодитой бус утга агуулсан;
  - б/ Төрийн байгууллагад нөлөөлөх чадвартай гэсэн утгатай;
  - в/ Өөрийгөө магтсан тайлбар гаргах;
  - г/ Бусад мэргэжил нэгт нөхөдтэйгөө харьцуулалт хийсэн мэдээ;
  - д/ Өөрийн тухай бусад хүмүүсийн магтаал агуулсан мэдээ тараах;
  - е/ Бусад өрсөлдөгчидтэй харьцуулахад илүү хямд гэж сурталчилах;
  - ж/ Ул үндэслэлгүй мэдэгдэл гаргах;
- 5.3. Үнэлгээчдийн хоорондын өрсөлдөөний арга нь үйлчилгээний үнэ хөлсийг үндэслэлгүй бууруулах явдал байж үл болно.
- 5.4. Үнэлгээчдийн өрсөлдөөний талбар нь үйлчилгээний чанар, гэрээт ажил гүйцэтгэгчийн мэдлэг, чадвар, туршлага, зарим өвөрмөц салбарын мэдлэг зэрэгтэй холбоотойгоор хуримтлагдан бий болох нэр хүнд, олон түмний итгэл хүлээх явдал байна.
- 5.5. Бусад үнэлгээчний нэр хүндэд харшилж болох аливаа үйлдлийг эрс хориглоно.

### **Зургаа. Ажил үйлчилгээний үнэ хөлсний ёс зүй**

- 6.1. Үйлчилгээний үнэ хөлс нь гүйцэтгэсэн ажлын хэмжээнээс хамаарах бөгөөд энэ нь үйл ажиллагааны зардал, ашгийг тусгасан байвал зохино.
- 6.2. Үйлчилгээний үнэ хөлснөөс гадна үйлчилгээний явцад гарах зардлыг тусад нь үйлчлүүлэгчээс гаргуулж болно.
- 6.3. Үйлчилгээний үнэ хөлс нь үйлчилгээний тодорхой үр дүнгээс шалтгаалан өөрчлөгдөх эсвэл тодорхой хувиар өсөх буюу буурах хандлагыг агуулж болохгүй.

### **Долоо. Хяналт шалгалт, дүгнэлт**

- 7.1. Үнэлгээчин ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд Мэргэжлийн Хариуцлага, Ёс Зүйн Хороо хяналт тавина.

## ТӨСӨЛ

7.2. Үнэлгээчний ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг дараах үндэслэлээр шалгана:

- а/ Иргэд, үйлчлүүлэгч этгээдийн ирүүлсэн хүсэлт, гомдол, мэдээллээр;
- б/ Институтийн **Мэргэжлийн Хариуцлага, Ёс Зүйн Хорооны** шийдвэрээр;
- в/ Өөрөө хүсэлт гаргаж бодит үнэнийг тогтоолгохоор;
- г/ Бусад.

7.3. Мэдээлэл хүргүүлж байгаа этгээдийн нэр, утас, хаяг тодорхой байвал зохино.

### **Найм.Шийтгэл**

8.1. **Мэргэжлийн Хариуцлага, Ёс Зүйн Хороо** нь үнэлгээчдийн гаргасан зөрчлийн шинж байдлыг харгалзан дараах шийтгэлийн аль нэгийг ноогдуулах тухай санал гаргана. Үүнд:

- а/ Институтийн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр хугацаатай даалгавар өгч сануулах;
- б/ Үнэлгээний үйл ажиллагаа явуулах эрхийг 3 сар хүртэл хугацаагаар түтгэлзүүлэх;
- в/ Үнэлгээний тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг Үнэлгээчдийн сонгон шалгаруулах орон тооны бус комиссоор дамжуулан Сангийн сайдад хүргүүлэх;
- г/ Ёс зүйн зөрчил гаргасан тухай тэмдэглэлийг үнэлгээчний мэдээллийн санд (хувийн хэрэгт) бүртгэх;
- г/ Ёс зүйн зөрчил гаргаж 8.1-ийн б, в зүйлд заасан шийтгэлийг ноогдуулсан үед олон нийтэд мэдээлнэ.

### **Ес. Үл зөвшөөрөх**

9.1. **Үнэлгээчин Мэргэжлийн Хариуцлага, Ёс Зүйн Хорооны дүгнэлтийг эс зөвшөөрвөл Институтийн Удирдах Зөвлөлд гомдол гаргаж болно.**